



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах
асуудлыг дэмжих тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Буянт-Ухаа 1" хорооллын 6 авто зогсоол, "Буянт-Ухаа 2" хорооллын 2 зорийн давхар, Хэнтий аймгийн Шинэ Өндөрхаан хорооллын 2 авто зогсоол, Хэнтий аймгийн "30 айл орон сууц"-ын зорийн давхар, Хэнтий аймаг Бор-өндөр сумын "20 айлын орон сууц"-ны 7 тоот, 2 ерөө орон сууц, Баянхонгор 30 айлын орон сууцны зорийн давхрын барилгыг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, "Буянт-Ухаа 2" хорооллын 400 автомашины нэгдсэн зогсоолын дуусаагүй барилгыг зориулалтын дагуу барьж ашиглах нөхцөлтэйгөөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг дэмжсүгэй.

2. Дээрх 6 барилга байгууламжийн нээлттэй дуудлагын худалдахтай холбоотой материалын бүрдлийг ханган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг 2024 оны 12 сард багтаан танилцуулахыг Хөрөнгийн ашиглалт зохицуулалтын газрын дарга /Ч.Маргад-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Л.Амгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ